



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 2/112

Улаанбаатар хот

О.Анх-Эрдэнэд буцалтгүй тусламж
олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 7.3.12-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн Хяналтын инженер Оогоны Анх-Эрдэнийн гаргасан өргөдөл, эхнэрийн эрүүл мэндийн шалтгаан, ар гэрийн аргагүй байдлыг харгалзан үзэж, нэг удаагийн буцалтгүй тусламж 1,000,000 төгрөг /нэг сая/-ийг олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн зардал 1,000,000 төгрөг /нэг сая/-ийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга, Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР